

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ УЛААН-УУЛЫН АЛТНЫ
ШОРООН ОРДЫГ АШИГЛАХ ТӨСЛИЙН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР MV-007137/
/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР 2550466/



АГУУЛГА

ОРШИЛ	4
НЭГ. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	5
Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын мэдээлэл	5
Төслийн байршил	5
Ашиглалтын систем	6
Уурхайн нээлт	6
Үйлдвэрлэлийн нөөц	6
Төслийн хүчин чадал	7
Уурхайн ажиллах горим	7
Уулын ажлын төлөвлөлт	7
Хүний нөөц	7
Цахилгаан хангамж	8
Усан хангамж	8
Хог хаягдал	9
ХОЁР.БАЙГАЛЬ ОРЧИН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	11
1. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	11
2. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	16
3. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	17
4. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	17
5. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	17
6. ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	17
7. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	19
8. БОМТ-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	21
9. ОРЧНЫ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	23
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДАЛ	27
ДҮГНЭЛТ	28



ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.Төслийн талбайн солбилцол.....	3
Хүснэгт 2.Хотхоны цэвэр усны хэрэглээ.....	5
Хүснэгт 3.Зам усалгааны тооцоо.....	6
Хүснэгт 4.Технологийн ус.....	6
Хүснэгт 5.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	6
Хүснэгт 6.Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	15
Хүснэгт 7.Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө.....	17
Хүснэгт 8.Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	18
Хүснэгт 9.Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	20
Хүснэгт 10.Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	22
Хүснэгт 11.БОМТ-н хэрэгжилтийг төрийн байгууллага болон оршин суугчид, оролцогч тайлагнах хуваарь.....	24
Хүснэгт 12.Байгаль орчин менежментийн төлөвлөгөөний зардал.....	25

ОРШИЛ

Зорилго: “Монголросцветмет” ТӨҮГ-ын алтны уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арга хэмжээ буюу зайлшгүй хийж гүйцэтгэх ажлыг төлөвлөхөд байгаль орчны менежментийн төлөвлөгөө оршино.

“Монголросцветмет” ТӨҮГ-ын алтны шороон ордын байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчин, аялал жуулчлалын яамны сайдын 2014 оны 1дүгээр сарын 06-ны өдрийн А-05 тоот тушаалаар батлагдсан аргачлалыг баримталсан бөгөөд БОМТ-нд багтах нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө зэрэг ажлууд хийгдэхгүй болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах, тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, БОМТ-ний хэрэгжилтийн талаар оршин суугчид, оролцогч талуудтай тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан.

2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажилд 10,000.0 мян.төг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ гарах үр дүн, хариуцан эзэн баримталж ажиллах арга зүй, стандарт, холбогдох хууль тогтоомжийг тусгаж зардлын задаргааг тусгав.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ, гол зорилт

Энэхүү тайлангийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт нь дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.Үүнд:

- Агаарын чанар хөрсөн бүрхэвч, гүний усанд төслийн үйл ажиллагаанаас үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг багасгах, бууруулах, арга хэмжээг тогтоох.
- Байгаль орчны төлөв байдалд хяналт тавих хугацаа, хариуцах эзэнг тогтоох.
- Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх явцад мөрдөх эрх зүйн баримт бичгийг тодорхойлох
- Шаардлагтай хөрөнгө зардлыг урьдчилсан байдлаар тооцож тодорхойлох зэрэг орно.



НЭГ. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын мэдээлэл

Хүснэгт 1. Төслийн мэдээлэл

№	Үзүүлэлтүүд		
1	Аж ахуйн нэгжийн нэр		“Монголросцветмет” ТӨҮГ
2	Улсын бүртгэлийн дугаар		9019029071
3	Төслийн нэр		“Улаан-Уул”-ын алтны ордыг ил аргаар ашиглах
4	Төслийн байршил	Нийслэл/Хот/ Аймаг	Төв аймаг
5		Сум/Дүүрэг	Заамар сум
6	Аж ахуйн нэгжийн хаяг	Аймаг/Хот	Улаанбаатар хот
7		Сум/Дүүрэг	Баянзүрх дүүрэг
8		Баг/Хороо	22-р хороо
9		Гудамж/Байр	Алтан Өлгий, Энхтайвны өргөн чөлөө өөрийн байр.
10		Шуудангийн хайрцаг	
11	Захирагч	Утас	
12		Нэр	Б.Чагнаадорж
13		Утас	99113837
14		Факс	
15		Гар утас	


Төслийн байршил

“Улаан-Уул”-ын орд нь Эрдэнэт хотоос зүүн урагш 100 км–т Улаанбаатар хотоос баруун хойш 260 км–т, Дархан хотоос баруун урагш 240 км–т, Өгөөмөр тосгоноос 1.6 км–т байрладаг. Засаг захиргааны хувьд Төв аймгийн Заамар суманд хамаарагдана.

Хүснэгт 2. Талбайн солбилцол

№	Газарзүйн солбицлын систем					
	град	мин	сек	град	мин	сек
1	104	26	19.12	48	16	22.1
2	104	26	19.12	48	14	49.1
3	104	24	42.1	48	14	49.1
4	104	24	42.1	48	15	36.41
5	104	25	1.1	48	15	36.41
6	104	25	1.1	48	15	1.1
7	104	24	42.1	48	15	52.75
8	104	24	42.1	48	16	22.1

Зураг 1. “Улаан-Уул”-ын алтны шороон ордын байршлын зураг

**Төслийн нэр:**

“Улаан-Уул”-ын алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөл. /Ордыг нийт 3 жилийн турш ашиглахаар төлөвлөсөн.

Ашиглалтын систем

Ордыг ил аргаар, авто тээвэртэй ашиглалтын системээр ашиглана.

Уурхайн нээлт

Ил уурхайг гадаад траншей малталтаар нээх ба хөрсний хамгийн бага зузаантай хэсгээс буюу В-6-26-1 дугаар блокын зүүн урд талаас 01-р хайгуулын шугамын дагуу 963м-ийн түвшинээс 80 промилийн налуутайгаар 945м-ийн түвшин дэх нөөцийн блокын хил хүртэл нэвтэрч ил уурхайг нээхээр уг төсөлд тусгав. Цааш В-6-28, В-6-29 нөөцийн блокын хилийн дагуу чиглэлд экскаваторын нэг орлын (гадаад овоолгын орон зай орсон оролт) хэмжээгээр ачилт хийж гүйцэтгэнэ.

Ордын уул техникийн нөхцөл нь уурхайн нээлтийг аль ч хэсгээс хийх боломжтой байна. Уурхайн нээлтэд уул-техникийн хувьд хүндрэл гарахааргүй байгаа юм. Уурхайн нээлтийг дотоод траншейгаар В зэргийн 1, боломжтой С зэргийн 1, нийт 3 блокыг нээн олборлолтын болон хөрс хуулалтын ажлыг эхлэн явуулна.

Үйлдвэрлэлийн нөөц

Ордын батлагдсан нөөц В+С зэргээр 386.11кг үүнээс олборлосон 129.91кг, давхцалд ороогүй үлдэж байгаа нь 256.2кг, 2012онд олборлосон 120.5кг түүнээс



135.7кг тус тус үлдэж буй энэхүү нөөцийг ашиглах үеийн техник эдийн засгийн үндэслэлийн тооцоог хийж гүйцэтгэсэн.

Төслийн хүчин чадал

Ордыг 3 жилийн хугацаанд олборлоно. Ил уурхайн жил бүрийн олборлолт харилцан адилгүй байна. Ашиглалтын 1 жилийн хугацаанд нийт 17,183,55 мян.м³ шимт хөрс хуулж, 2,026,651,29 мян.м³ хөрс хуулж, 95,126,58 мян.м³ элс олборлоно.

Уурхайн ажиллах горим

“Улаан-Уул”-ын уурхайн хөрс хуулалт, элс олборлолтын ажлыг 2023 оны 5 сараас эхлэхээр төлөвлөсөн 2023 онд 05 сараас 8-р сар хүртэл ажиллана. Уурхайн үйл ажиллагаа нь тасралтгүй ажиллагаатай явагдах бөгөөд Монгол Улсын хууль тогтоомжуудад заасны дагуу олон нийтээр амрах баяр ёслолын хоногууд, цаг агаарын хүндрэл, засвар үйлчилгээ зэрэг хүчин зүйлүүдийг тооцон жилд ажиллах хоногийг тооцов. Уурхай хоногт 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна. 2 ээлжийн хугацаанд нийт 183-190 хоног ажиллана.

Уулын ажлын төлөвлөлт

“Улаан-Уул”-ын ордын ашиглалтын хугацаанд нийт 17,183,55 мян.м³ шимт хөрс хуулж, 2,026,651,29 мян.м³ хөрс хуулан, 95,126,58 мян.м³ элс олборлоно.

Хүний нөөц

“Улаан-Уул”-ын уурхайд 112 хүн, оффист - 30 хүн нийт төслийн хүрээнд “Шижир алт”-ны үйлдвэрт 82 хүн ажиллах ба сарын дундаж цалин 900 мян.төгрөг болно.

Уурхайн ашиглалтын жилийн хугацаанд ЭМНДШ-т байгууллага 200 сая төгрөг төлнө.

Хүснэгт 3. Уурхайн барилга байгууламж

№	Барилгын нэр	Хэмжих нэгж	Хэмжээ	Тайлбар
Хотхон				
1	Уурхайн удирдлагын байр	м2		Удирдлагын байр-1
2	Ажилчдын сууц	м2	232	Ажилчдын байр-6
3	Цайны газар	м2		Цайны газар-1
Ил уурхай				
4	Засварын талбай	м2	100	Талбай-1
5	Сэлбэгийн агуулах	м2		Агуулах -2
6	Түлшний машин	тн	2,5	Машин-1
7	Харуулын байр	м2		Байр-1

Цахилгаан хангамж

“Улаан-Уул”-ын ордын хувьд баяжуулах хэсгийн тоног төхөөрөмж, ажилчдын хотхон, уурхайн гэрэлтүүлэг гэсэн хэсгүүдэд цахилгааны хэрэглээ үүсдэг.

Дархан-Сэлэнгийн цахилгаан дамжуулах шугамнаас 35 кВт-ын тэжээл салаалуулан 1,8 км цахилгаан дамжуулах агаарын шугам татсан.

Усан хангамж

Уурхайн усны хэрэглээг уурхайн лицензийн талбайд өрөмдөн гаргасан худгаас хангах ба замын усалгаа болон биологийн нөхөн сэргээлтийн усалгааг хангана. Угаах төхөөрөмжийн технологийн усны хэрэглээг Туул голоос 1,8 км-ээс 45 диаметрийн ган хоолой татаж 80 мян.м³ эзэлхүүнтэй усан санг сард 2 удаа сэлбэдэг.

Ахуй хэрэглээний усны тооцоо

Орд ашиглалтын үед уурхайд 200 хүн ажиллахаар тооцсон. Уурхайн ажилчдын усны хэрэглээг 2015.07.31-ний өдрийн БОАЖЯ-ны сайдын тушаалаар батлагдсан Ус хэрэглээний нормоор тооцсон.

Хүснэгт 4. Хотхоны цэвэр усны хэрэглээ

Ажиллах жил	Ажилчдын тоо	Ажиллах хоног дундажаар	Нэг хүний хоногийн усны хэрэглээ	Хоногт шаардлага тай усны хэрэглээ	Жилийн усны хэрэглээ	Шаардлага тай ундаргын хэмжээ
Х. нэгж	хүн	хоног	л	м ³	м ³	л/с
1 жил	200	190	150	30,000	5700,0	0,13
НИЙТ					5700,0	0,13

Орд ашиглалтын нийт хугацаанд 5700,0 м³ ус хэрэглэхээр байна.

Улаан уулын алтны шороон ордоос төв суурин газруудтай ердийн хээрийн орон нутгийн чанартай шороон замаар холбогдоно. Ил уурхайн автозам нь автосамосвалын даац ачаа эргэлт хөрсний бүтцээс хамаарч замын төрөл, хийц, янз бүрийн хучилттай тавигддаг.

Ил уурхайн автозамын нэвтрүүлэх чадвар, ил уурхайн ажиллах нийт хугацаанаас хамаарч ердийн хөрсөн замыг уурхайгаас баяжуулах буюу угаах хэсгүүдэд хэрэглэхээр төсөлд тусгалаа. Ашиглалтын хугацаанд нийт 10 метрийн өргөнтэй 3км урттай зам гаргаж байнгын засвар үйлчилгээ (автозамын ачаа эргэлтээс хамаарч услах, үер уснаас хамгаалах далан шуудуу татах) зэрэг ажлыг хийж ажиллана. Зам засварын ажилд CAT D8, CAT D9 маркийн бульдозеруудыг ашиглана.

БОАЖЯ-ны сайдын 2015.07.30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 13 дугаар хавсралтад зааснаар гудамж, зам, талбай услах усалгааны норм 2л байна. Усалгааг зуны 3 сард нийт 90 удаа усална. Нийт автозамын өргөн 10м, урт нь 3.0км байна.



Хүснэгт 5. Зам усалгааны тооцоо

жил	Зам усалгаа м ³				
	Норм (л/м ³)	Талбай м ²	Жилд услах хоног	Жилд услах хэмжээ м ³ ус	Нийт ашиглалтын хугацаанд услах хэмжээ м ³ ус
1	2	30	90	2700	5400

Уурхайн орд ашиглалтын хугацаанд нийт 5400 м³ ус зам усалгаанд ашиглахаар тооцоо гарч байна.

Технологийн усны хэрэгцээний тооцоо

Баяжуулах үйлдвэрийг хоногт дундажаар 1600 м³ элсийг угаана гэж үзвэл хоногт 6400м³ ус зарцуулна. Баяжуулах төхөөрөмжийн хаягдал усны бүрэлдэхүүнд хаягдал булинга, шүүлтүүрийн шүүгдэс болон үйлдвэрийн машин, тоног төхөөрөмжийн цэвэрлэгээний бохир ус зэрэг багтана. Технологийн зориулалтаар хэрэглэгдэх цэвэр усны хэмжээг багасгах, хаягдах усны хэмжээг бууруулах зорилгоор түүнийг эргүүлэн ашиглахаар тооцов. Усан сангаас гарсан усны 70%-ийг эргүүлэн ашиглана.

Төслийн хэмжээнд жилд боловсруулах нийт элсний хэмжээ – 95000м³

Технологийн усны хэрэглээ

Хүснэгт № 6

№	Нэр	Нэгж	1-р жил	2-р жил
1	Цагт зарцуулах усны хэмжээ	м3/цаг	351.089	351.089
2	Хоногт зарцуулах усны хэмжээ	м3/хон	7372.869	7372.869
3	Жилд зарцуулах усны хэмжээ	мян.м3/жил	728.1771	621.1066
4	Жилд зарцуулах эргэлтийн усны хэмжээ	мян.м3/жил	218.45313	186.33198
5	Жилд зарцуулах цэвэр усны хэмжээ	мян.м3/жил	509.72397	434.77462

Хаягдлын аж ахуйд эргэлтийн усны систем ашиглан үйлдвэрлэлийн хаягдалтай хамт хаягдсан усыг цэвэрлэн үйлдвэрлэлд эргүүлэн хэрэглэх шаардлагатай бөгөөд орон нутгийн хөрсний шингээлт, ууршилтын тайлангүй учир бусад үйлдвэртэй харьцангуйгаар технологийн нийт хэрэгцээт усны 70%-ийг эргүүлж ашиглана гэж тооцоолсон.

Баяжуулах үйлдвэрийн усан хангамжид одоо үйлдвэрт байгаа Д-315, Д-320 маркын насосуудыг ашиглахаар төлөвлөөө.

Хог хаягдал.

Хатуу хог хаягдал

Хог хаягдлын менежмент нь хүний эрүүл мэндийг хамгаалах, ажилчид, нутгийн оршин суугчдын ажиллаж амьдрах таатай нөхцлийг бүрдүүлэх, хүрээлэн буй орчинд дам үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэгдсэн.

Уурхайн үйл ажиллагааны явцад хор аюултай, элдэв хог хаягдал гарахгүй, харин хөрс хуулалт, алт олборлох явцад үүсэх галь, эфель, бул чулуу зэргийн



хаягдлыг уурхайн малтмалд оруулж техникийн нөхөн сэргээлтэд ашиглахгүй ил задгай хаявал тэр нь хатуу хог хаягдал болно. Нөхөн сэргээлтийг зохих технологийн дагуу хийж чадсан нөхцөлд тэр нь зохиомол хурдас болж хувирна.

Уурхайгаас гарах ахуйн гаралтай хатуу хаягдлын эх үүсвэр нь ажилчдын хэрэглээ, хоол бэлтгэлийн явцад байх болно.

Уурхайн үйл ажиллагаанаас хүнсний зүйлсийн сав, баглаа боодол, бие засах газрын хаягдал, ундааны сав, лааз болон бусад хаягдал, хоолны үлдэгдэл зэрэг бусад зүйлсүүд орно.

Ил уурхай нь жилд дундажаар 190 хоног ажиллана. Хоногт нэг хүнээс 0,3 кг хатуу хог хаягдал гарна гэж тооцвол хоногт $200 \text{ хүн} * 0,3 \text{ кг} = 60 \text{ кг}$, харин жилд $200 \text{ хүн} * 0,3 \text{ кг} * 190 = 11,400 \text{ кг}$ орчим хатуу хог хаягдал гарахаар байна.

Ахуйн гаралтай хог хаягдлыг тусгайлан бэлтгэсэн хогийн түр хураах цэг байрлуулах бөгөөд түр хураах цэгт таглаа, битүүмжлэл сайтай хогийн саванд хийнэ. Хог хаягдлын цэгийг салхины зонхилох чиглэлийн доор тогтсон нэг цэгт байрлуулж, уурхайгаас гарах хатуу хог хаягдлыг тухай бүр ариутгаж, овор хэмжээг нь багасгах зэргээр байгаль орчинд үзүүлэх хор нөлөөг багасгах хэрэгтэй.

Шингэн хаягдал

Уурхайн барилгын ажил болон олборлолтын ажлын үед ашиглагдаж буй машин, тоног төхөөрөмжүүдэд зохих хуваарийн дагуу техникийн үйлчилгээ хийх үед ажилласан тос, тосолгооны хаягдал материал гарахаар байна. Мөн уг уул уурхайн үйл ажиллагаа явагдахын зэрэгцээ ажилчдын зүгээс ахуйн чанартай шингэн хаягдлууд гарна. Үүнд

- Хоол хүнсний хаягдал
- Цэвэрлэгээнээс гарсан бохир ус
- Бие засах газрын хаягдал зэрэг болно.

Уурхайд тогтмол 200 хүн ажиллах ба хоногт $30,000 \text{ м}^3$, сард 900 м^3 , жилд $5700,0 \text{ м}^3$ цэвэр ус хэрэглэнэ. Эндээс хоногт дундажаар $19,3 \text{ м}^3$, сард $135,2 \text{ м}^3$, жилд $207,7 \text{ м}^3$ орчим ахуйн хаягдал бохир ус гарахаар байна. Дээрх тооцоог 1 хүн хоногт дундажаар 150 л цэвэр ус хэрэглэхээр, бохир усны хэмжээг цэвэр усны хэмжээний 70%-иар тооцож гаргалаа.



ХОЁР.БАЙГАЛЬ ОРЧИН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 7.

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	Урьдчилан сэргийлэх, бууруулах арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нэгжийн өртөг мян.төг	Зардал /мян.төг/ 2023 он	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаарын орчин							
1	Цаг уурын нөхцөл байдлаас уул техникийн үйл ажиллагаанаас үүсэлтэй хүний эрүүл мэндэд хортой тоосжилт үүсэх	Уурхайн олборлолтын үе шатанд тоосжилт ихээр үүсэх үед усалгаа хийх, хуурайшилт ихтэй үед тоос багасгах арга хэмжээ авах	Хуурайшилт ихтэй үед өдөр болгон усалгаа хийх		Дотоод төлөвлөлт-өөр	байнга	-Агаарын ба агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль -MNS 0017-2-3-16-1998 хүн ам суурьшсан хэсгүүдэд /бензин хөдөлгүүрт/ MNS 5013-2003 дизель хөдөлгүүрт MNS 5014-2003-2010 MNS4585-2007 агаарын чанар техникийн ерөнхий шаардлага MNS4890-2000ХААЭА ажлын байрны орчин, эрүүл ахуйн шаардлага MNS 3383-1982 агаар мандал бохирдуулагч эх үүсвэрийг тодорхойлох
2	-Машин техник, тоног төхөөрөмжийн ашиглалт, шатах тослох материалын ууршилт ажилчдын суурингаас бохирдуулагч бодис тархах,	Хүнд машин механизмын хөдөлгүүрийн тохиргоо үйлчилгээг тогтмол хийх хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлагад нийцүүлэхийн тулд хяналт шалгалтыг тогтмол хийх	Стандарт хугацаанд агаар шүүгч, тос маслын шүүрийг сольж байх		Дотоод төлөвлөлтөөр	байнга	
3	-Уурхайн олборлолтын үеийн хөрс хуулалт, олборлолт, овоолго зэрэг газар шорооны ажилтай холбоотой тоосжилт үүсэх Хог хаягдлын үнэр ялгарах -Төслийн үйл ажиллагаанаас үүссэн тоосжилт, хорт хий газарт бууж ургамалан бүрхэвч ба хөрсөнд нөлөөлөх						
Дуу шуугиан							
4	Физик бохирдол дуу чимээний нөлөөлөл нутгийн иргэдийн	Тоног төхөөрөмжүүдийн суурийн бэхэлгээ, аюулгүй	Засвар үйлчилгээний	200,0	Удирдлага зохион	Жилд 1 удаа	MNS-12.1.06:1988 Хөдөлмөрийн аюулгүй



	амгалан тайван байдлыг алдагдуулах	ажиллагааг шалгаж байх техник төхөөрөмжүүдийн засвар үйлчилгээг тогтмол хийж байх, олон цагаар дуу чимээ ихтэй газарт ажиллаж буй ажилтны сонголыг хамгаалах чихэвч зүүлгэнэ. Дуу шуугианы хэмжилт хийлгэх, дуу шуугиан бүхий машин механизмын ашиглалтыг оновчтой төлөвлөх, үр ашиггүй ашиглалтыг багасгах	ажилд хамаарна		байгуулалтын ажилд тусгагдсан.	дууны түвшин хэмжигч ИЛ-04 багажаар хэмжилтийг хийлгэнэ	байдлын стандартын систем Дуу шуугианы хамгийн өндөр түвшин, аюулгүй байдлын шаардлага, MNS-12.4.005:1985 Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа
Гадаргуун болон гүний ус							
5	Хаврын шар ус, үерийн улмаас уурхайн үйл ажиллагаанд нөлөөлөх Ахуйн хог хаягдал, бохир, шатах тослох материалын алдагдлаас газрын доорхи усны чанар доройтох. Үерийн усаар дамжин гадаргууд алдагдаж болзошгүй.	Төслийн хэрэгжилтийн хугацаанд үерийн уснаас хамгаалах, үерийн усыг чиглүүлэн урсгах далан, суваг, шуудууг бэлтгэх бөгөөд ашиглалтын дараа нөхөн сэргээх, Бохирдолтой орчныг яаралтай цэвэрлэж, дор бүр ариутгал хийн, усны хяналт шинжилгээг тогтмол хийлгэх	Уурхайн эргэн тойронд үерийн далан хийх		Дотоод төлөвлөлтөөр		-Усны тухай хууль - Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль - Ус ашигласны төлбөр -Усны орчны чанарын үзүүлэлт MNS-4586:1998 -Гүний усыг бохирдлоос хамгаалах MNS-3342:1982
6	- Шатах тослох материалыг алдаж хөрсийг бохирдуулснаас газрын доорхи ус бохирдох	Зуны улиралд үер бууж уурхайн овоолго зам талбай усанд автаж болзошгүй учир үерийн уснаас хамгаалах хатуу хог хаягдлаар бохирдуулахгүй байх арга хэмжээ авч шуудуу, хамгаалалтын далан барих	Уурхайн эргэн тойронд үерийн далан хийх	-	Дотоод төлөвлөлтөөр	Уурхайн ажил эхлэхийн өмнө	
7	-Эргэлтийн усан сангаас баяжуулалтын технологийн ус шүүрч алдагдах						
Хөрсөн бүрхэвч							
8	-Техник болон хүний нөлөөгөөр хөрс болон ургамлыг гэмтээх -Уурхайн ашиглалтын явцад	Тээврийн хэрэгслийг зөвхөн баталгаажуулсан замаар явуулж байх, маршрутын бус	Уурхайн замыг маршрутын дагуу хийж		0,4	Уурхайн ажил	MNS-5344:2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэх ерөнхий шаардлага



	хөрсний бүтэц найрлагад өөрчлөлт орох, хог хаягдал тоосжилтоос бохирдол үүсэх	замаар явхыг хориглосон тэмдэг тэмдэглээ тавьж өгөх	баталгаажуулж тэмдэг тэмдэгээ тавих			эхлэхийн өмнө	MNS-3297:1991 Хөрс,хот суурин газрын эрүүл ахуйн үзүүлэлт , MNS-5850:2008 Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис, элементүүдий зөвшөөрөгдсөн дээд хэмжээ, MNS-4601:2011 автотээврийн хөдлөх бүрэлдэхүүн, техникийн засварын тогтолцоо, үйлчилгээ
9	-Шатах тослох материал асгарах, гэнэтийн болзошгүй аваар ослоос үүдэн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах -Хөрсний овоолго, усан сан бохир ус цэвэрлэх байгууламжийн лагийн талбай доорхи хөрс дарагдах. Шимт байдлаа алдах,	Тээврийн хэрэгслийг зөвхөн баталгаажуулсан замаар явуулж байх, маршрутын бус замаар явхыг хориглосон тэмдэг тэмдэглээ тавьж өгөх Өнгөн хөрсийг хуулан авах, уурхайн үйл ажиллагаа эхлэх үед өнгөн хөрсийг хуулж шимт хөрсийг овоолох	Уурхайн замыг маршрутын дагуу хийж баталгаажуулж тэмдэг тэмдэгээ тавих Шимт хөрсний овоолго		0,4	Уурхайн ажил эхлэхийн өмнө	хууль -Хөрс хамгаалах цөлжилтөөс хамгаалах тухай хууль Үйл ажиллагаа эхлэхийн өмнө
10	-Хүнд даацын машин техникийн үзлэг, засварын ажлын хүрээнд нефтийн бүтээгдэхүүнээр ахуйн хог хаягдал, бохир усаар хөрс бохирдох, олон салаа зам үүсэх,тоос шороо босох, ургамал сүйтгэх, хөрсийг халзлах	Хөрс, хаягдал чулуулгийн овоолго, усан сан, бохир ус цэвэрлэх байгууламжийн лагийн талбай үүсгэх талбайн үржил шимт хөрсийг хуулах, нөхөн сэргээлтэнд ашиглахаар хадгалах, ашиглах,	Нөхөн сэргээлтийн ажилд тусгагдах Шимт хөрсний овоолго бий болгох		Дотоод төлөвлөлтөөр	Уурхайн үйл ажиллагаа а эхлэхийн өмнө	
11	-Хөрс хатуу хог хаягдлаар бохирдох	Засвар үйлчилгээ, шатах тослох материалаар машин техникийг цэнэглэхдээ ШТМ алдагдсан ч хөрсөнд нэвчихээргүй байх аюулгүй ажиллагааны арга хэмжээ авч зориулалтын саванд хадгалах,уурхайн орчимд асгарч алдагдахаас сэргийлэх	Дотоод төлөвлөлтөөр			байнга	
12		ШТМ-ын агуулах болон засварын төвийн талбайг хайргажуурах, газрын гадарга хөрс бохирдохоос сэргийлэх/плеонк дэвсэх, бетондсон талбай бэлтгэх	ШТМ-ын агуулах засварын талбай		1300,0	1300,0	
Ургамал							



13	Олборлолт, уурхайн засвар үйлчилгээ, уурхайд олон салаа зам үүсэнээс болж байгалийн ургамал устгах Агаарын тоосжилт бохирдол, хөрсний бохирдлын улмаас ургамлын ургах чадварыг алдагдах	ШТМ-ын агуулах болон засварын төвийн талбайг хайргажуулах, ургамлан нөмрөгийг бохирдохоос сэргийлэх Машин техникээс гарах тоос, хорт утааг багасгах үүднээс тухайн орчныг чийгшүүлэх, үзлэг оношлогоонд тогтмол оруулах	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан. Агаар мандлыг хамгаалах арга хэмжээнд тусгагдсан.	Хөрсөн бүрхэвчийг хамгаалах БОХ төлөвлөгөөнд тусгагдсан	Уурхайн ажил эхлэхийн өмнө	Ургамлын тухай хууль MNS-5914:2008 БО-ны эвдэрсэн газрын нөхөн сэргээлт -MNS-5915:2008 уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал -MNS-5916:2008 БО үржил шим хөрсийг хуулах шаардлага
	-Хатуу шингэн хог хаягдлыг ил задгай хаяснаас болж ургамлан бүрхэвч бохирдох, талхлагдах	ШТМ-ын агуулах болон засварын төвийн талбайг хайргажуулах, ургамлан нөмрөгийг бохирдохоос сэргийлэх Машин техникээс гарах тоос, хорт утааг багасгах үүднээс тухайн орчныг чийгшүүлэх	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан. Агаар мандлыг хамгаалах арга хэмжээнд тусгагдсан.	Хөрсөн бүрхэвчийг хамгаалах БОХ төлөвлөгөөнд тусгагдсан	Уурхайн ажил эхлэхийн өмнө	Ургамлын тухай хууль MNS-5914:2008 БО-ны эвдэрсэн газрын нөхөн сэргээлт -MNS-5915:2008 уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал -MNS-5916:2008 БО үржил шим хөрсийг хуулах шаардлага
		Хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх, хог хаях нэгдсэн цэг байгуулах	Хогийг ялган ангилах сав тавьж, тэмдэг тэмдэглээ тавих	Хог хаягдлын төлөвлөгөөнд орсон	Жил бүр	-MNS-5916:2008 БО үржил шим хөрсийг хуулах шаардлага -Ургамал хамгаалалын тухай /2007 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр/
		Жил бүр ургамлын судалгаа мониторинг явуулах, нөхөн сэргээлт хийх, олон үрийг орон нутгийн цаг уурын онцлогт тохирсон үрийг худалдан авах,	Уурхайн ажилчдад болон орон нутгийн иргэдэд ажлаа тайлагнах	Дотоод төлөвлөлтөөр	Жил бүр	
Амьтан						



14	Төслийн хэрэгжилтийн явцад элдэв шавьж өсч үржих, ингэснээр элдэв нянгийн бохирдлын эх үүсвэр бий болох	Ажилчдын түр сууц, суурин, түүний цогцолбороос гарах хатуу, шингэн хаягдлыг зориулалтын тусгай цэгт эмх цэгцтэй хадгалах, зохих цэвэрлэгээ, халдваржуулалт хийж байгаль орчинд халгүй аргаар тогтмол хугацаанд зайлуулж байх	Үйл ажиллагаа явуулж буй талбайг эргэж тойрон хашаалах тэмдэг тэмдэглээ тавих	Агаарын бохирдлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тусгагдсан		
15	Үйл ажиллагааны улмаас амьтны нөөц хомсдох Уурхайн карьерт мал амьтан унах, олборлолтын үед мэрэгч, мөлхөгчдын амьдрах орчин алга болж тэнд үүрлэх шавьжууд устах -Шувуу нүүдлийн хөхтэн амьтад дайрч өнгөрөх зам хаагдах	Уурхайн талбайд мал амьтан унаж гэмтэхээс сэргийлэх зорилгоор хамгаалалт хашаа хийх		Агаарын бохирдлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тусгагдсан		
	Уурхайн ажилчид хууль зөрчсөн тохиолдолд хулгайн хариуцлага хүлээх асуудлаар сургалт мэдээллийг тогтмол өгөх	Ажилчдын тосгонд галт зэвсэг болон бусад зэвсэг хэрэглэхийг хориглох		Уурхайд	300,0	Уурхайн ажил эхлэхийн өмнө
Орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээ						
	Төслийн хэрэгжилтийн үед улс орон болон бүс нутгийн ашиг орлогыг нэмэгдүүлэх	Бүс нутгийн оршин суугчдын ажилгүйдлийг бууруулах,	Улс,аймаг, сум орон нутгийн төсөвт даатгалын шимтгэл төлбөрүүдийг оруулах, нийгмийн хариуцлагын хүрээнд сумын дэд бүтэцийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах	Дотоод төлөвлөлтөөр	Олборл олтын үйл ажиллаг ааны явцад	
	НИЙТ			2600,0		



2. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчин, геологи, уул уурхайн хууль тогтоомжийн эмхэтгэл, Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль болон бусад хууль, тогтоол шийдвэрийн дагуу уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг уурхайн үйл ажиллагааг явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллага Монгол Улсын стандартын дагуу зайлшгүй хийсэн байх үүрэгтэй.

“Улаан-Уул”-ын алтны шороон ордын уурхайн орчмын газрын хэвлий, газрын гадарга, хөрс, гадаргын усан сүлжээ, ургамалан нөмрөгт үүсэх эвдрэлийг техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн арга хэмжээ авч, нөхөн сэргээх ажлын хэмжээ, холбогдох зардлыг төрийн захиргааны төв байгууллагаас батласан журам, аргачлал, стандарт шаардлагын дагуу нарийвчлан тооцох зорилготойгоор энэхүү төлөвлөгөөг боловсруулсан болно.

Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх нь ашигт малтмалын болон байгаль орчны хуулийн заалтыг хэрэгжүүлэх гол үндэс юм.

Дараах хууль дүрмийг баримтлан хэрэгжүүлэх шаардлага тавигдана. Үүнд:

- MNS5914:2008 Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн нэр томъёо, тодорхойлолт,
- MNS5915:2008 Уул уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал,
- MNS5916:2008 Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт,
- MNS5917:2008 Уул уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын техникийн нөхөн сэргээлт
- MNS5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн шаардлага,
- MNS4919:2008 Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс. Техникийн шаардлага,
- MNS4920:2008 Эвдэрсэн газрын хажуугийн налуу. Техникийн шаардлага,
- Ашигт малтмал эрж хайх ажлын явцад эвдэрсэн газрыг нөхөн сэргээж ургамалжуулах заавар /БО, ХААҮ-н Сайдын 2000 оны 64/А/62 тоот тушаалын 3-р хавсралт/.

Хүснэгт 8. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Зардал /мян.төг/ 2023 он	Хэрэгжүүлэгч байгууллага
	Уурхайн бэлтгэл ажлын үед	Техникийн нөхөн сэргээлт-5 га	2023 онд	Дотоод төлөвлөлтөөр	“Монголпросцветмет” ТӨҮГ-ын харьяа “Шижир алт” алтны үйлдвэр
		Шимт хөрсний овоолгыг хамгаалах			
		Биологийн нөхөн сэргээлт-3 га	2023 онд		
	Тэрбум мод хөдөлгөөний хүрээнд мод тарих	Төв аймгийн Заамар суманд 5,000 ш мод	2023 онд	Дотоод төлөвлөлтөөр	
	Нийт			Дотоод төлөвлөлтөөр	



3. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Улаан уул” алтны шороон ордын уурхайд 2023 онд дүйцүүлэн хамгаалах ажил хийгдэхгүй байхаар төлөвлөж, Уулын ажлын төлөвлөгөө батлуулсан.

Харин хил залгаа орших MV-000175 тусгай зөвшөөрөлтэй “Туул голын гольдрил” ордын талбай дээр Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас өгсөн чиглэлийн дагуу эвдэрч, эзэнгүй орхигдсон 10 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж, орон нутагт хүлээлгэн өгнө.

4. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Улаан-Уул”-ын алтны шороон ордын талбайн ойр орчим нөлөөллийн бүст айлын өвөлжөө, хаваржаа бүхий газартай давхцаагүй учир нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох ажил хийгдэхгүй.

5. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус ордын талбайд одоогоор энэ төрлийн олдвор олдоогүй. Хэрэв уурхайн эдэлбэр газрын хүрээнд түүх соёлын дурсгалын зүйлс, археологи, палентологийн олдвор илэрсэн тохиолдолд сум, аймгийн захиргаанд болон мэргэжлийн байгууллагуудад мэдэгдэж, зохих судалгаа, шинжилгээ хийлгэн дүгнэлт гаргуулна.

6. ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Энэ төлөвлөгөөнд батлагдсан аргачлалын дагуу хийсэн байгалийн аюул, гамшгийн үнэлгээгээр тогтоогдсон учирч болзошгүй байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах зардлыг тусгалаа.

Гэнэтийн осолд урьдчилан тооцоолоход нэн бэрх байгалийн гамшигт үзэгдлүүдийг хамруулах үзэх бөгөөд үүнд газар хөдлөл, усны үер, салхи шуурга, аянга цахилгаан, гал түймэр, үйлдвэрлэлийн осол, халдварт өвчин тархах зэрэг үзэгдлүүдийг авч үзэж болох юм. Гэнэтийн иймэрхүү осол болох тохиолдолд төслийн хүрээнд байгаль орчныг бохирдуулах зэрэг хохирол учруулах нь харьцангуй их байна.

Газар хөдлөлт

Тус уурхайн байрлах газар нутаг нь газар хөдлөлтийн 6 баллын бүсэд хамаарна.Энд газар хөдлөлт ба чичирхийлэл болоход алт олборлох үйл ажиллагаа нь харьцангуй гүн ил уурхайд явагдах тул газар хөдлөлтийн онцгой нөхцөлд уурхайн малталтын хэсэг догол хажуу нурж тэнд ажиллаж буй хүн, тоног төхөөрөмж дарагдах аюул ослын эрсдэл гарах магадлал өндөртэйг анхаарч ажиллах шаардлагатай юм.Газар хөдлөл нь байгалийн гамшгийн хамгийн аюултай хэлбэрийн нэг бөгөөд газар хөдлөлийг урьдчилан тогтоож ,мэдээлэх боломж муу.Газар хөдлөлийн улмаас шугам сүлжээ гажих,тасрах,барилга байгууламжид ан цав гарах, нурах, ус дамжуулах хоолойнууд болон хаягдал дамжуулах хоолой эвдрэх,цоорох гэх мэт хохирол,сүйрэл гарч болзошгүй.



Салхи, шуурга

Тухайн бүс нутагт хаврын улиралд үе үе хүчтэй салхитай байдаг бөгөөд салхины хамгийн дээд хурд 20м/сек-ээс хэтрэх тохиолдол олонтаа тохиолддог. Мөн тухайн нутаг дэвсгэрт цаг агаарын олон жилийн дунджаар 15м/сек-ээс их салхитай өдөр 10, шороон шуургатай өдөр 33, цасан шуургатай өдөр 10 удаа тохиолдож, салхины их хурд 16-30 м/сек, ялангуяа хаврын саруудад 28-34 м/сек хурдтай салхилах тохиолдол цөөнгүй гардаг тул агаарт тоос босохоос сэргийлэх арга хэмжээг үүсэх нөхцөл бүрээр төлөвлөж, техникийн ба биологийн нөхөн сэргээлтийн ажлыг уялдуулж хийнэ.

Үерийн усны аюул

Үер усны аюул нь зарим тохиолдолд газар хөдлөлтийн сүйтгэлээс багагүй хохирол учруулж хүний амь нас эрсдэх магадлал ихтэйгээс гадна байгаль орчныг бохирдуулдагын хувьд уурхай, үйлдвэрийн орчин төдийгүй их талбайг хамаарч хөрс ургамалд удаан хугацаагаар сэргэшгүй хохирол учруулж болно. Улаан-Уулын шороон ордын уурхайн бүс нь харьцангуй өндөрлөгт орших тул жилд цөөн тохиолдох үерийн аюулд бага өртөнө. Гэхдээ карьерын мөргөцгийн талбайнууд, доод уланд бороо, цасны ус их хэмжээгээр хуралдаж, хажуу хана, бортны сулралт үүсгэж, нурал гарах нөхцөл бүрдэж болзошгүй байдлыг тооцож урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

Аянга цахилгаан

Энэ бүс нутагт жилдээ дунджаар 20 өдөр аянга цахилгаантай байдаг хамгийн олондоо 40-н өдөр хүрч байсан. Аянгатай бороотой 7-р сард хамгийн удаан үргэлжилдэг юм. Энэ нь уурхайн техник хэрэгсэл, хүмүүсийн үйл ажиллагаа хөдөлмөрийн нөхцөлд түр саатал бэрхшээл учруулж улмаар аюул тохиолдож болох магадлалтай. Хэдийгээр Өгөөмөр тосгоны ойролцоо аянга зайлуулагч байгаа ч болзошгүй ослын үед металл хийц бүхий тоног төхөөрөмж, гар утсаар дамжин ажиллагсад аянга цахилгааны осолд өртөхөөс сэргийлж ажиллана.



Хүснэгт 10. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, арга хэмжээ авах	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг	Зардал /мян.төг/ 2023 он	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн бичиг баримт
1.	Аюул үүсэх болзошгүй аюул осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж	Дотоод төлөвлөлтөөр		Байнга	Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003 /Сүүлийн нэмэлт өөрчлөлт 2012.05.17/ Гамшгийн холбогдолтой нэр томъёо, тодорхойлолт, ерөнхий анги
		Галын болон болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах	Уурхайн ажилчдад ИТА-ыг хамруулах		1000,0	Жилд 1 удаа	
		Галын дохиоллын систем суурилуулах, гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах	Ажилчдын хотхон орчимд		500,0	Үйл ажиллагааны туршид	
2.	Байгалийн гэнэтийн аюулт үзэгдэл	Уурхайн эргэн тойронд үерийн уснаас хамгаалах суваг, шуудуу, хамгаалах далан хаалт байгуулах	Далан байгуулах	Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөнд орсон.	Дотоод төлөвлөлтөөр		
Нийт					1500,0		

7. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хатуу хог хаягдал

Уурхайн барилгын ажил болон олборлолтын ажилд хэрэглээд илүү гарсан машин, техникийн сэлбэг, эд ангийн баглаа боодол, машины дугуй, сольсон хуучин сэлбэг, замын тэмдэглэгээ, тэдгээрийн холбогдох хэрэгсэл, эрэг боолт зэрэг хаягдлууд бий болно.

Уурхайн ажилчдаас ундааны сав, лааз, цаас, нийлэг эд материалууд, хөвөн даавуу болон малын яс гэх мэт хүмүүсийн эдэлж хэрэглэсэн янз бүрийн ахуйн хэрэглээний хог хаягдал гарна.

Шингэн хаягдал



Уурхайн барилгын ажил болон олборлолтын үед ашиглагдаж буй машин, тоног төхөөрөмжүүдэд зохих хуваарийн дагуу техникийн үйлчилгээ хийх үед ажилласан тос, тосолгооны хаягдал материал гарахаар байна.

Хүснэгт 11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Нэгжийн өртөг	Зардал /мян.төг/ 2023 он	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	Хог хаягдлаас үүсэх орчны бохирдол	Ахуйн хог хаягдлаа орон нутагтай гэрээ байгуулан тээвэрлүүлэх	Хог хаягдлын гэрээний дагуу 360,0 төгрөгийг төрийн сангийн дансанд байршуулах	Дотоод төлөвлөлтөөр	Долоо хоногийн 1 дэхь өдөр	Хог хаягдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/
		Ахуйн хатуу хог хаягдал хаях сав байрлуулах	250,0	500,0	Уурхайн ажил эхлэхийн өмнө	
		Хатуу хог хаягдлын цэгийн гадна талд болон бусад орчинд хог алдагдахаас сэргийлэн хашаа барих	500,0	1000,0	Уурхайн ажил эхлэхийн өмнө	
Нийт				1500,0		



8. БОМТ-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Улаан-Уул”-ын алтны шороон ордын үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэйгөөр үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж, мэргэжлийн боловсон хүчнээс бүрдсэн байгаль орчны асуудал хариуцсан байгаль орчны мэргэжилтэн ажиллуулах ба төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээг авч ажиллах боловч төслийн удирдлагын хэмжээнд онцгойлон анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна.

Байгаль орчныг хамгаалах, хяналт тавих, нөхөн сэргээлт хийх ажлыг байгаль орчны мэргэжилтэн хариуцан ажиллах бөгөөд жил бүр гүйцэтгэх ажлын хэмжээ болон зардлыг байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаж ажиллана. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Нөхөн сэргээлтийн болон байгаль хамгаалах ажлыг урьдчилан төлөвлөсний дагуу дэс дараалалтай хийж гүйцэтгэх,
- Компанийн удирдлага нь байгаль орчны холбогдолтой бүх хууль тогтоомжийн дагуу уурхайн үйл ажиллагааг удирдан зохион байгуулахаас гадна хуулийн өмнө хариуцлага хүлээнэ.
- Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг заасан хугацаанд нь холбогдох байгууллагуудад хүргүүлж, тайлагнаж байх,
- Байгалийн гэнэтийн аюултай үзэгдэл /газар хөдлөлт, үер, салхи, шуурга/ болон үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллагсдыг жилд 1 удаа сургаж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах, энэ талаар дотоод журам төлөвлөгөөтэй ажиллана.
- Хуурайшилт ихтэй үед хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, гал түймрийг унтраах багаж хэрэгслийг бэлтгэж, байнга бэлэн байлгах,
- Ахуйн хог хаягдлыг байнга цэвэрлэн ариутгаж байх, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж байх.



Хүснэгт 12. Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг	Зардал /мян.төг/ 2023 он	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	Уурхайн удирдлагын авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд	Байгаль орчны удирдлага, зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Уурхайн ажилчид		Дотоод төлөвлөлтөөр	Байнга	MNS5002:2000 ХАБЭА Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага, MNS 12.4. 005-1985
		Ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах	Уурхайн ажилчдад		Дотоод төлөвлөлтөөр	Жилд 1 удаа	
		Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхижүүлэх уулзалт зөвлөгөөнийг жил бүр зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОМТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах	Уурхайн ажилчид	-	1000,0	Жилд 1 удаа	
		Байгаль орчны аудитыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Уурхайн удирдлага	Мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах		2 жил тутамд	
		Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах	Уурхайн ажилчдад		1000,0	Жилд 1 удаа	
		Ажиллагсдыг жилд 1 удаа эрүүл мэндийн үзлэгт оруулах	Уурхайн ажилчид		Дотоод төлөвлөлтөөр	Жилд 1 удаа	
Нийт					2000,0		



9. ОРЧНЫ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр /ОХШХ/ нь “Монголросцветмет” ТӨҮГ-аас явуулж буй үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэг чухал баримт бичиг юм.

“Улаан Уул”-ын алтны шороон ордын үйл ажиллагааны явцад БОННУ-ний тайлан, БОМТ-д тусгасан болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор тогтмол дээжлэлт, сорьц авч байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь баримтлах стандарт, аргачлал, зардлыг тодорхойлон ОХШХ-т тусгав.

Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулиудын дагуу “Монголросцветмет” ТӨҮГ нь батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулах шаардлагатай. Тухайн жилд хийсэн хяналт, шинжилгээний үр дүнгүүдийг жил бүрийн 11 дугаар сарын 01-ний дотор холбогдох төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн хянуулж, дараа оныхоо төлөвлөгөөг батлуулж ажиллах ёстой.



Хүснэгт 13. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Байршил	Хяналт шинжилгээний ажлын хэмжээ	Нэгжийн өртөг	Зардал /мян.төг/ 2023 он	Баримтлах стандарт ба аргачлал	Дээд доод хязгаар
Агаарын орчин								
	TSP	Мкгр/м ³	Уурхай, ажилчдын байр орчим, хог хаягдлын цэг	Жилд 2 удаа	24 цагийн хэмжилтийг хийж, цаг агаарын үзүүлэлтүүдийн хамт тооцоход 36,0 мян.төг 14 цэг*36,0	900,0	MNS17.2.316-88 суурин газрын агаарын чанарыг хангах MNS 3384:82 агаар мандлын сорьц авахад тавигдах ерөнхий шаардлага MNS5585:2008 агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ техникийн шаардлага	24 цагийн дундаж – 100, жилийн дундаж- 500
	PM ₁₀	Мкгр/м ³						24 цагийн дундаж – 50, жилийн дундаж- 25
	PM _{2.5}	Мкгр/м ³						20 минутын дундаж 500, 20 минутын дундаж 450, 4 цагийн дундаж 20, жилийн дундаж 10.
	NO ₂ / азотын давхар ирсэл	Мкгр/м ³						10 минутын дундаж 500, 20 минутын дундаж 450, 4 цагийн дундаж 20, жилийн дундаж 10
	SO ₂ хүхэрлэг хий	Мкгр/м ³						30 минутын дундаж 60000, 1 цагийн дундаж 30000, 8 цагийн дундаж 10000
	CO/ нүүрстөрөгчийн дутуу исэл	Мкгр/м ³	Уурхай орчмоос		3000 Ажлын 10 байр	100,0		16 цагийн дундаж 60, 8 цагийн дундаж 50
	Дуу чимээ							
Хөрсөн бүрхэвч								
	Механик бүрэлдэхүүн	%	Техноген нөлөөлөлд өртөөгүй хяналтын цэгт Ажилчдын суурин орчимд Уурхайн үйлдвэрийн	Жилд 2 удаа 5 цэгт	Хөрсний химийн шинжилгээ хүнд металын шинжилгээ	1200,0	-УСТ 3298-90 Хөрснөөс шинжилгээнд дээж авахад тавигдах шаардлага -УСТ 3297-91 Хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлт	Хэмжилтээр
	Ялзмагт үеийн зузаан	см						Хэмжилтээр
	Ялзмаг	%						Хэмжилтээр
	карбонат	%						21
	Нефтийн бүтээгдэхүүний агууламж	Мг/100гр						5,9
	Хүнд	Мг/100гр						1,8



элементийн агууламж		орчимд					
Бусад бохирдлын үзүүлэлтүүд	Mг/100гр						хэмжилтээр
Усан орчин							
Усны бохирдлын шинжилгээ		Гүний худаг, эргэлтийн усан сан, туул голын ус, ундны ус,	Жилд 2 удаа, 6 цэг	Усны ерөнхий шинжилгээ – Хүнд металын шинжилгээ –	200,0	-MNS 3934:1986 Ундны болон үйлдвэрийн ус – Химийн шинжилгээ хийх- дээж авах, хадгалах, зөөвөрлөх, - MNS /ISO/ 566711:2000 Усны чанар, дээж авах. 11-р бүлэг. Гүний уснаас дээж авах зөвлөмж - MNS 900:2009, Хүний унд ахуйн зориулалттай усны чанарын норм, - MNS 6148 – 2010 Усны чанар. Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ	
Нийт					2400,0		

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах шатанд олон нийтийн оролцоо, тэр дундаа алтны шороон ордын сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн иргэд, орон нутгийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, хууль тогтоомжид заасан хүрээнд тэдэнд аль болох ойлгомжтой бөгөөд үнэн зөв, бодит мэдээллийг өгч, зөрчигдөж болзошгүй эрхээ хамгаалах, санал бодлыг тусгах нь энэ шатны ажлын гол зорилт юм.



Хүснэгт 14. БОМТ-ний хэрэгжилтийг төрийн байгууллага болон оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

№	БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
	Төв аймаг, Заамар сумын Хайлааст 3-р Багийн ИНХ	Уулзалт, санал асуулга	БОМТ болон хяналт, шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах	11-р сар	Нутгийн иргэдийн саналыг хавсаргах	Төв аймгийн Заамар сум
	БОАЖЯ-ны БНУГ	Тайлангийн эх хувь, албан бичиг	Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх	12-р сар		БОАЖЯ-нд
	Байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага	Танилцуулж тайлагнах	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн талаар	11-р сар	Цаашид анхаарах асуудал	ЗДТГ



БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДАЛ

Хүснэгт 15. БОМТ-ний нийт зардал

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Нийт зардал /мян.төг/ 2023 он
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	2600,0
2.	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	40,000.0
3.	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	0
4.	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	0
5.	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	0
6.	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1500,0
7.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1500,0
8.	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	2000,0
9.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	2400,0
	Нийт	50,000,0



ДҮГНЭЛТ

Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-007137 тусгай зөвшөөрөлтэй “Монголросцветмет” ТӨҮГ-ын “Улаан Уул” алтны шороон ордын 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахад дараах дүгнэлтэнд хүрлээ.

“Улаан-Уул”-ын алтны шороон ордын олборлолтоос хөрс хамгийн ихээр элэгдэл эвдрэлд өртөх учир тээврийн хэрэгслийг тогтсон нэг маршрутын дагуу явуулах, нөхөн сэргээлтийг цаг тухай бүр хийх зайлшгүй шаардлагатай.

“Монголросцветмет”ТӨҮГ-ын удирдлагын зүгээс БОМТ, ОХШХ-ийг байгаль орчны мэргэжилтэнд хариуцуулан дээж авч шинжлүүлэх, үр дүнг тайлагнан эрх бүхий байгууллагаар батлуулах шаардлагатай.

2023 оны БОМТ-нд 50 сая төгрөг зарцуулахаар төсөвлөж, тухайн ажлуудын хэмжээ, гарах үр дүн, хариуцах эзэн, холбогдох стандарт, дүрэм журам, хууль тогтоомжийг тусган, зардлын задаргааг байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын хэсэгт оруулав.